



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛ.
ЭВДЭРСЭН ГАЗРЫН СЭРГЭЭН САЙЖРУУЛАЛТ
НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ**

MNS 17.5.1.13 - 80

Албан хэвлэл

СТАНДАРТЧИЛАЛ ХЭМЖИЛЗҮЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Улаанбаатар хот

**Хөдөө аж ахуйн яамны улсын газар зохион байгуулалтын
хайгуул зураг төслийн институтээс боловсруулав.**

Орлогч захирал

Г.Пүрэвцэрэн

Боловсруулсан:

Ахлах инженер

С.Чимэддамба

Үнэ, стандартын эрдэм шинжилгээний институтээс бэлтгэв.

Захирал

Т.Дөрбетхан

Эрдэм шинжилгээний ажилтан

(ЭША)

Д.Зандармаа

Үнэ, стандартын улсын хорооны 1980 оны

85 тоот тогтоолоор батлав.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Байгаль орчны хамгаалалт, эвдэрсэн газрын сэргээн сайжруулалт. Нэр томьёо, тодорхойлолт Охрана природы. Рекультивация земель термины и определения	MNS 17.5.1.13 - 80
	ГОСТ 17.5.1.01-78

Үнэ, стандартын улсын хорооны 1980 оны 85-р тогтоолын дагуу 1981 оны 6-р сарын 1-нээс 1985 оны 6-р сарын 1-ний өдөр хүртэл мөрдөнө.

Стандартыг зөрчвөл хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

Энэ стандарт нь эвдэрсэн газрыг сэргээн сайжруулах асуудалтай холбогдуулан шинжлэх Ухаан, техник болон үйлдвэрлэлд хэрэглэх нэр томьёо, тодорхойлолтыг тогтооно.

Энэхүү стандартаар тогтоосон нэр томьёог улс ардын аж ахуйд хэрэглэгдэх бүх төрлийн албан ёсны баримт бичиг, шинжлэх ухаан, техник, сургалтын болон лавлах материалд заавал хэрэглэнэ.

Стандартаар тогтоосон тодорхойлолтын хэлбэрийг тухайн шаардлагаар өөрчилж болох боловч тайлбарын ухагдахуун, ойлголтын хүрээг өөрчилж болохгүй.

Стандартчилагдсан ойлголт тус бүрд нэг нэр томьёо тогтоосон . Үүнийг өөр нэр томьёогоор сольж хэрэглэхийг хориглоно.

Энэхүү стандартаар тогтоосон нэр томьёог цагаан толгойн үсгийн дэс дараагаар жагсааж, хавсаргав.

Стандартаар тогтоогдсон нэр томьёог том үсгээр, товч утга агуулгыг жижиг үсгээр, сольж хэрэглэж болохгүй, ойролцоо үгийг дор нь жижиг давтан бичиж тус тус тэмдэглэсэн болно.

Нэр томьёо	Тодорхойлолт
1. Эвдэрсэн газар О.Нарушенные земли	Ерөнхий ойлголт Хүний үйл ажиллагаанд хөрс, усных нь горим өөрчлөгдөх, үүсмэл гадарга бий болох зэргээр аж ахуйн ач холбогдлоо алдаж, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэх нөхцөлтэй болж байгаа газар. <u>Тайлбар:</u> 1. Ашигт малтмал болон хүдрийг

1	2
<p>2. Эвдэрсэн газрыг сэргээн сайжруулах. О.Рекультивация земель</p>	<p>боловсруулахад болон барилга байгууламж барих, геологи хайгуулын ажлыг гүйцэтгэх зэрэг бусад ажлаас болж газар эвдэрдэг ; 2. Хөрс, усны горим өөрчлөгдөх, гадаргын хэлбэр дүрс эвдрэн үүсмэл гадарга буй болохоос гадна газрын чанар байдалд бусад өөрчлөлтүүд гардаг. Эвдэрсэн газрын аж ахуйн ач холбогдол болон газрын үр шимийг дээшлүүлэх, хүрээлэн байгаа орчны нөхцөлийг сайжруулахад чиглэгдсэн цогцолбор ажиллагаа.</p>
<p>3. Эвдэрсэн газрын бүртгэл О.Инвентаризация нарушенных земель</p>	<p><u>Тайлбар:</u> Газрыг ухаж малтаж үйлдвэрлэлээ явуулдаг газрын үйлдвэрлэлийн технологийн ажиллагааны салшгүй хэсэг нь тэдгээр эвдэрсэн газрыг сэргээн сайжруулах явдал байх ёстой.</p>
<p>4. Үүсмэл шинж О.Техногенез</p>	<p>Эвдэрсэн газрын байршлыг газар дээр нь илрүүлж, зураглал гарган хэмжээ, чанар байдлыг тогтоох</p>
<p>5. Үүсмэл гадарга О.Техногенезный рельеф</p>	<p>Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад байгалийн цогцолборын хувиран өөрчлөгдөх шинж</p>
<p>6. Эвдэрсэн газрыг сэргээн сайжруулах чиглэл О-Направление рекультиваций земель</p>	<p>Хүний үйл ажиллагааны нөлөөгөөр газрын гадаргын унаган төрх алдагдаж, бий болсон үүсмэл гадарга Эвдэрсэн газрыг улс ардын аж ахуйд тодорхой чиглэлээр ашиглах.</p>

1	2
<p>7. Эвдэрсэн газрыг хөдөө аж ахуйн чиглэлээр сэргээн сайжруулах.</p> <p>О.Сельскохозяйственноое направление рекультиваций земель</p>	<p>Эвдэрсэн газруудад хөдөө аж ахуйн эдэлбэр бий болгох</p>
<p>8. Эвдэрсэн газрыг ойн аж ахуйн чиглэлээр сэргээн сайжруулах</p> <p>О.Лесохозяйственное направление рекультиваций земель</p>	<p>Үүсмэл гадаргын хотгор хэсэгт янз бүрийн зориулалтын усан сан бий болгох</p>
<p>11. Эвдэрсэн газрыг амралт зугаалгын чиглэлээр сэргээн сайжруулах.</p> <p>О.Рекреационное направление рекультиваций земель</p>	<p>Эвдэрсэн газрыг сэргээн сайжруулах амралтын объект</p>
<p>12. Эвдэрсэн газрыг ариун цэвэр, эрүүл ахуйн чиглэлээр сэргээн сайжруулах</p> <p>О.Санитарно-гигиеническое направление рекультиваций земель</p>	<p>Эвдэрсэн газрыг сэргээн сайжруулах нь улс ардын аж ахуйд эдийн засгийн хувьд үр ашиггүй бол хүрээлэн байгаа орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөг нь биологийн ба техникийн аргаар зогсоох</p>
<p>13. Эвдэрсэн газрыг барилга байгууламж барих чиглэлээр сэргээн сайжруулах</p> <p>О.Строительное направление рекультиваций земель</p>	<p>Эвдэрсэн газрыг үйлдвэрийн ба иргэний барилга байгууламж барихад тохиромжтой болгох</p>
<p>14. Хөрсжүүлэлт</p> <p>О.Землевание</p>	<p>Үржил шим багатай газрыг сайжруулах зорилгоор үржил шимт үе давхаргыг юмуу үржил шимийн чадавхи боломж бүхий чулуулгийг хуулах, зөөх, тараан асгахад чиглэсэн цогцолбор ажиллагаа</p>

MNS 17.5.1.13 - 80

1	2
<p>15. Сэргээн сайжруулах газар О.Объект рекультиваций земель</p>	<p>Сэргээн сайжруулбал зохих эвдэрсэн хэсэг газар <u>Тайлбар:</u> Сэргээн сайжруулах газар гэдэгт уурхайн малтаас, хүлэр авсан газар, суултын хонхор, цөмөрхий, овоолго, шуудуу болон ухагдаж эвдэрсэн газрууд хамаарагдана.</p>
<p>16. Уурхайн шаталсан малтаас О.Террасированная карьерная выемка</p>	<p>Эвдэрсэн газрын төрөл Газрын гүнийн ашигт малтмалыг олдворлохоор хэд хэдэн мөрөгцөг гарган ухсан малтаас</p>
<p>17. Уурхайн тогоо хэлбэрийн малтаас О.Котловинообразная карьерная выемка</p>	<p>Өнгөн хэсгийн ашигт малтмалыг олдворлох үед 10 метрээс илүү гүнзгий дан мөрөгцөг гарган ухсан битүү хонхор</p>
<p>18. Уурхайн занга хэлбэрийн малтаас О.Западинообразная карьерная выемка</p>	<p>Өнгөн хэсгийн ашигт малтмал олборлох үед 10 метр хүртэлх гүнд дан мөрөгцөг гарган ухсан битүү хонхор</p>
<p>19. Уурхайн хамарлуулж ухсан тогоо хэлбэрийн малтаас О.Котлованно-грядовая карьерная выемка</p>	<p>Гидро агаар ашигт малтмалыг олдворлоход тогтоолж ухсан нүхийг хаалттай хослуулан хэрэглэхэд үүссэн нүх</p>
<p>20 Уурхайн хамарлаж ухсан шуудуун малтаас О.Траншейно-грядовая карьерная выемка</p>	<p>Урт гүн шуудуу, хаалтыг хослуулах аргаар ашигт малтмалыг олдворлоход үүссэн малтаас</p>
<p>21. Уурхйн тэгшилсэн малтаас О.Выровненная карьерная выемка</p>	<p>Их хэмжээний талбайтай хүдрийн ордыг ашиглахад үүссэн ёроолтой малтаас</p>

1	2
22. Уулын гүнийн уурхайн шатлуулсан малтаас О.Нагорно-глубинная терасированная карьерная выемка	Уулын гүнийн ашигт малтмалыг олдворлоход хэд хэдэн мөрөгцөг гарган ухахад бий болсон уурхайн малтаас
23. Уулын уурхайн шатлуулж ухсан малтаас О.Нагорно-глубинная террасированная карьерная выемка	Уулын ашигт малтмалыг олдворлоход хэд хэдэн мөргөцөг гарган ухахад бий болсон уурхайн малтаас
24. Урт, гүн шуудуу О.Траншеи	Хөндлөн огтлол нь трапец хэлбэртэй, уртыг нь өргөн ба гүнтэй жишихэд мэдэгдэхүйц их, уурхайн ил боловсруулалтын үед ухагдсан газар.
25. Овоолго О.Отвал	Зориуд бэлдсэн талбайд хураасан уулын чулуулаг <u>Тайлбар:</u> Уурхайгаас гаргаж хураасныг гаднах овоолго дотроо хураасныг доторх овоолго гэнэ.
26. Тавцан хэлбэрийн овоолго О.Платообразный отвал	Тээврийн хэрэгсэл буюу гидро-механикжуулалтыг ашиглан нэг дан үе үүсгэн хавтгай ороотой хураасан овоолго <u>Тайлбар:</u>
27. Тавцан хэлбэрийн шатлуулсан овоолго О.Платообразно-террасированный отвал	Гидромеханикийг ашиглахад хөрсний гидроотвал, төмөрлөгийн үйлдвэрлэлийн ба дулааны цахилгаан станцын хаягдал болон ашигт малтмалыг баяжуулсны дараах хаягдлаас овоолго үүсдэг. Тээврийн хэрэгслийг ашиглан хэд хэдэн үе үүсгэн хураасан овоолго

MNS 17.5.1.13 - 80

28. Хярласан овоолго О.Гребневидный отвал	Экскаватор юмуу хөмөргөн малтагчаар конус хэлбэрээр хярлуулан асгасан гадаргуу бүхий тогтоцтой овоолго
29. Хүдрийн хаягдал О.Терриконик	Уурхайн уулын чулуулгийг буюу баяжуулалтын хаягдлыг конус хэлбэрээр асгасан овоолго
30. Суултын хонхор О.Мульда оседания	Ашигт малтмалыг олдворлоход уулын чулуулаг доош сууснаас газрын гадаргад үүссэн хонхор
31. Хотон О.Прогиб	Газрын дор олдворлолт хийснээс юмуу хураасан овоолго нягтарснаас газрын гадаргын хагаралтгүйгээр дагуудаа доош суусан хэсэгт
32. Цөмөрхий О.Провал	Ашигт малтмалыг олдворлох үед газрын гадаргад гарч доош суусан хонхор
33. Шаталсан цөмөрхий (нуранга) О-Террасированный провал	Шаталсан хэлбэрийн налуу хажуутай цөмөрхий (нуранга)
34. Хавцал маягийн цөмөрхий О.Каньонообразный провал	10 метрээс илүү гүн, огцом хажуутай, урт сунасан цөмөрхий
35. Далангийн дагуух ховил О.Резерв	Далан байгуулахаар уулын чулуулгыг гаргаж авахад үүссэн шуудуу
36. Дэл О. Кавальер	Шугаман барилга байгууламж барих үед ухсан шуудуунаас гарсан трапец хэлбэрийн чулуулаг
37. Эвдэрсэн газрыг сэргээн сайжруулах үе шат О.Этапы рекультиваций земель	Эвдэрсэн газрыг сэргээн сайжруулах үе шат Эвдэрсэн газрыг сэргээн сайжруулах иж бүрэн ажлыг гүйцэтгэх дэс дараалал

1	2
<p>38. Эвдэрсэн газрыг сэргээн сайжруулах техник ажиллагааны үе шат техник сэргээн сайжруулалт О.Технический этап рекультиваций земель</p>	<p><u>Тайлбар:</u> Ерөнхийдээ техникийн ба биологийн гэсэн 2 үе шатанд хуваагддаг Улс ардын аж ахуйд тодорхой зориулалтаар ашиглахын тулд эвдэрсэн газрыг сэргээн сайжруулахад бэлтгэх үе <u>Тайлбар:</u> Энэ үе шатны ажилд газрыг тэгшлэх, налууг өөрчлөх, хөрс болон үржил шимт чулуулгыг хуулж тээвэрлэн сэргээн сайжруулах газарт тараан асгах, зам гидротехникийн болон хөрс сайжруулалтын барилга байгууламж барих зэрэг ажлууд хамаарна.</p>
<p>39. Эвдэрсэн газрыг сэргээн сайжруулах биологын ажиллагааны үе шат биологи сэргээн сайжруулалт О.Биологический этап рекультиваций земель</p>	<p>Эвдэрсэн газрыг сэргээн сайжруулах техник ажиллаганы дараа хийгдэх, хөрсний үржил шимийг сэргээхэд чиглэгдсэн арга хэмжээ <u>Тайлбар:</u> Ургамал, амьтны аймгийг нөхөн сэргээхтэй холбогдсон агротехникийн болон фитомелиорацийн арга хэмжээнүүд хамаарна.</p>
<p>40. Хуулах чулуулаг О.Вскрышные породы</p>	<p>Ашигт малтмалыг халхалж байгаа, түүнтэй холилдсон, уул уурхайн ил аргаар</p>
<p>41. Нийтэд нь хуулах О.Валовая обработка вскрыши</p>	<p>ашиглахад зайлуулах ёстой чулуулаг. Холилдон байгаа төрөл бүрийн чулуулаг, хөрсийг ялгахгүйгээр гаргаж зайлуулах</p>
<p>42. Ангилан хуулах О.Селективная обработка вскрыши</p>	<p>Холилдон байгаа: төрөл бүрийн чулуулаг болон хөрсний ялзмаг үеийг тус тусад нь ялган гаргаж зайлуулах</p>
<p>43. Хамтад нь овоолох О.Валовое отвалообразование</p>	<p>Хуулагдсан чулуулаг ба хөрсийг тэдгээрийн агрохимийн болон физик, механикийн шинж чанараар нь ялгахгүйгээр овоолох</p>

MNS 17.5.1.13 - 80

1	2
<p>44. Ангилан овоолох О.Селективное отвалообразование</p>	<p>Хуулагдсан чулуулаг ба хөрсний ялзмаг хэсгийг тэдгээрийн агро химийн болон физик, механикийн чанараар нь ялгаж овоолох.</p>
<p>45. Тэгшилгээний ажил О.Горнопланировочные работы</p>	<p>Эвдэрсэн газрын гадаргыг тэгшлэх, ухсан малтаас, овоолгын хажууг алгуур болгох ажил</p>
<p>46. Газрыг нэлэнхийд нь тэгшлэх О.Сплошная планировка земель</p>	<p><u>.Тайлбар:</u> Овоолго ба ухсан малтаасан хажуу, налуугийн өнцгийг багасгах зорилгоор хийх газар шорооны ажлыг алгуур болгох гэнэ.</p>
<p>47. Газрыг хэсэгчилж тэгшлэх О.Частичная планировка земель</p>	<p>Эвдэрсэн газрыг хөдөө аж ахуйд болон механикжсан ажиллагаа явуулж ойн аж ахуйн зориулалтаар эзэмшихэд боломж бүхий налуу үүсгэн тэгшлэх</p>
<p>48. Газрыг урьдчилан тэгшлэх О.Грубая планировка земель</p>	<p>Эвдэрсэн газрыг хөдөө аж ахуйн болон механикжсан ажиллагаа явуулж ойн аж ахуйн зориулалтаар эзэмшихэд боломж бүхий налуу үүсгэн тэгшлэх</p>
<p>49. Газрыг бүрэн тэгшлэх О.Чистовая планировка земель</p>	<p>Газар шорооны үндсэн ажил гүйцэтгэхийн зэрэгцээ гадаргууг ерөнхийд нь тэгшлэх</p>
<p>50. Овоолгыг өөрчлөх О.Переформирование отвалов</p>	<p>Газар шорооны бага зэргийн ажлын үед гадаргууг бүрэн тэгшилж, бичил рельефүүдийг арилгах</p>
<p>51. Сэргээн сайжруулсан газрыг засах О.Ремонт рекультивируемых отвалов</p>	<p>Цаашид эзэмших боломжтой нөхцөлийг хангах, мөн дотроосоо шатахаас урьдчилан сэргийлэх, унтраах зорилгоор овоолгын хэлбэрийг өөрчлөх</p>
<p>52. Сэргээн сайжруулсан газрыг засах О.Ремонт рекультивируемых отвалов</p>	<p>Овоолгын чулуулаг нягтарснаасбуюу сэргээн сайжруулалтын үед эвдрэлийн ажиллагаа мөн зам болон гидротехникийн барилга байгууламжийн гэмтлээс үүссэн тэгш бусыг арилгах ажил</p>

1	2
52. Чулуулгыг сайжруулах О.Мелиорация пород	Сэргээн сайжруулах газрын гадаргыг үүсгэж буй чулуулаг болон тэдгээрийн холимогийн физик химийн шинж чанарыг сайжруулахад чиглэгдсэн ажил Тайлбар: Сайжруулалтын энэ ажилд шаваржуулах, элжүүлэх, шохойжуулах, угаах болон хөрсний орчныг өөрчлөхөд чиглэгдсэн бусад арга хэмжээнүүд хамаарна.
53.Сэргээн сайжруулагдаж буй үе давхарга О.Рекультивационный слой	Эвдэрсэн газрыг сэргээн сайжруулахдаа бий болгож байгаа ургамал ургах зохистой нөхцөл бүхий үе давхарга
54. Халхлах давхарга О.Экранирующий слой	Биологийн сэргээн сайжруулалтанд тохиромжгүй үе давхарга дээр, элс, хайрга, үүрмэг чулуу, саармагжуулагч асгаж түүний чийг огшуулах сүвийг хааж чадахуйцаар үүсгэсэн давхарга
55. Хөрсний үржил шимт давхарга О.Плодородный слой почвы	Ургамлын өсөлтөнд шаардагдах физик, химийн болон агро- химийн зохистой нөхцөл бүхий дээд хэсгийн ялзмагтай хэсэг
56 Үржил шимийн чадавхитай чулуулаг О.Потенциально-плодородные породы	Ургамлын өсөлтөд тохиромжтой физик химийн болон агро- химийн зарим шинж чанарыг агуулсан уулын чулуулаг
57. Тохиромж муутай чулуулаг О.Малопригодные породы	Физик химийн шинж чанар нь ургамлын өсөлт хөгжилтэнд хангалтгүй уулын чулуулаг Хялбар уусгагч давс, сульфидын эсдлэгийн
58. Тохиромжгүй чулуулаг О.Непригодные породы	үүсмэлийг ургамал болон амьтдыг хордуулахуйц хэмжээгээр агуулж байгаа уулын болон хадан чулуулаг.